



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“СЭЛЭНГЭ ҮРЖЛИЙН ЦӨМ СҮРГИЙН АЖ АХУЙ” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Сэлэнгэ нутгийн бренд нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө үүлдрийн хонийг өсгөн үржүүлэх, чанарыг нь хадгалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй “Сэлэнгэ Үржлийн Цөм Сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, үр дүнд холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс үнэлэлт, дүгнэлт хийгдээгүй байна.



Сүхбаатар сум
2016 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Шинжээч Ж.Цогт 2016 оны 08 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ- ын байрны Өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Хоёр. Үндсэн мэдээлэл Гурав. Аудитын дүн - ОНӨААТҮГ- уудын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу. - Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу - Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу. - Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу. - ОНӨААТҮГ-ууд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу. - Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу. - Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу. - Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх. - Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт үр ашигтай байна уу. -Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу -Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу -Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллогыг цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу. Дөрөв. Илрүүлсэн зөрчил Тав. Аудитын дүгнэлт Зургаа. Зөвлөмж Холбогдох байгууллагын санал: Саналд өгсөн тайлбар
---	--

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨХ	Төрийн Өмчийн Хороо
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МЭҮТ	Мал эмнэлэг, үржлийн тасаг
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль

Нэг. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Аудитын нэр: “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн.

2. Аудитын код: СЭАГ-2016/01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн / *Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй ОНӨААТҮГ-ын* / үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршив.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад 13 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны 1-5 сар хүртэлх үйл ажиллагаатай холбоотой гаргасан аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрүүд, аймгийн Засаг даргын захирамж, тус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, даргын тушаал, санхүүгийн баримтуудыг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогч, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийн, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийн, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад ОНӨААТҮГ-ын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон МУ-ын Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, бусад холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулагдана.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч Ж.Цогт 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Хоёр. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 07-р сарын 04-ны өдрийн 184-р тогтоолын дагуу “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ыг байгуулж, захирлаар нь Д.Бадарч томилогдсон байна. Тус ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Орхон, Ерөө сумдын нутагт нарийн, нарийвтар ноост Ерөө болон Орхон үүлдрийн шилмэл хонин сүргийг өсгөн үржүүлж байна.

“Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь захирал, мэргэжилтэн-1, малчин-5 нийт 7 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 оны эцэст нарийн, нарийвтар ноост Орхон үүлдрийн 932 , Ерөө үүлдрийн 436 толгой үржлийн хонь тоологдсон байна.

Тус ОНӨААТҮГ-нь 1314001001 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 3733491 тоот регистрийн дугаартай Төрийн банкны 15170002658 тоот харилцах дансаар орлого, зарлагын гүйлгээ хийж 2005 оноос 1-р гарын үсгийг захирал Д.Бадарч, 2-р

гарын үсгийг Ж.Эрдэнэчимэг нар тус тус зурж, хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Гурав. АУДИТЫН ДҮН

1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, үр дүнг аймаг, орон нутгийн холбогдох байгууллагууд авч хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна.

1.1 Цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалан бататгах ажил 2005 оноос хойш хийгдээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2005 оны 7-р сарын 05-ны өдрийн 184-р тогтоолоор “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-г байгуулсан бөгөөд үйлдвэрийн газрын дүрмийг Сэлэнгэ аймгийн Засаг дарга баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2011 оны 07-р сарын 28-ны өдрийн Б/06-р захирамжаар үйлдвэрийн газрын орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоожээ.

“Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө үүлдрийн хонины генофондыг хамгаалах, шилмэл мал бойжуулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, мал үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах үндсэн зорилготой бөгөөд дүрмийн дагуу дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар заасан байна. Үүнд:

- *Сэлэнгэ аймгийн аж ахуй нэгж, иргэд байгууллагыг цэвэр үүлдрийн мал амьтнаар хангах,*
- *Цэвэр үүлдрийн мал амьтны үр, үр хөврөл импортлох,*
- *Шилдэг малыг экспортлох,*
- *Цэвэр үүлдэр, түүний эрлийз малыг шилэн сонгох замаар шилдэг хээлтээгч, хээлтүүлэгч өсгөн бойжуулах,*
- *Иргэдийн малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж малын үүлдэрлэг байдал ашиг шимийг сайжруулах,*
- *Аж ахуйн нэгж, иргэдийг холбогдох мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх,*
- *Шинэ техник, технологи нэвтрүүлэх,*
- *Цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалан бататгах зэрэг болно.*

Үйлдвэрийн газар нь 2015 онд нарийн, нарийвтар ноост Орхон болон Ерөө үүлдрийн хонь, хурганд Орхон, Ерөө сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран үзлэг ангилалт хийж, өсвөр хээлтүүлэгч сонгох ба цөм сүрэгт баяжилт хийж малчдад зөвлөгөө өгч ажиллажээ.

Хонины зохиомол хээлтүүлгийн нүүдлийн 2 салбарыг Орхон, Ерөө сумдад тогтмол ажиллуулж, иргэд аж ахуйн нэгжийн хонинд зохиомол хээлтүүлэг хийхээс гадна ердийн хээлтүүлэгт Орхон, Ерөө үүлдэр, үүлдрийн хэсгийн хуцаар захиалгын дагуу үйлчилсэн байна. Дээрх ажлууд нь Орхон, Ерөө үүлдэр, үүлдрийн хэсгийн

хонины тархалтын хүрээг өргөтгөх, үүлдэрлэг байдлыг нь сайжруулахад чухал үр нөлөө бүхий үйл ажиллагаа болсон байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС-ийн Мал үржүүлгийн тэнхимтэй хамтран Орхон, Ерөө үүлдрийн хонины ноос, амьдын жин, хурганы өсөлт, махны гарцад судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгч иржээ.

Ерөө сумын ЗДТГ-тай хамтран Ерөө үүлдрийн хэсгийн хонины хургыг бордож, бэлчээрээр маллан монгол хонины хургатай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх зэргээр үйл ажиллагаагаа үр нөлөөтэй гүйцэтгэж байна.

“Шилмэл мал-2015” улсын үзэсгэлэнд Орхон үүлдрийн 7, Ерөө үүлдрийн хэсгийн 2, нийт 9 хоньтой оролцож, Орхон үүлдрийн 4236 дугаартай хуц амьдын жин 87 кг, ноосны гарц 4,5 кг-тайгаар ашиг шим, галбирын үзүүлэлтээр “Тэргүүн” байрт шалгарсан байна.

“Сэлэнгэ-Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь анх 2005 онд 333 толгой хоньтой байгуулагдаж байсан бол 2015 оны эцэст 1368 толгой хонь тоологдсон байна.

Орхон, Ерөө хонины тоо толгойг сүүлийн 5 жилээр харуулбал:

Хүснэгт-1

Он	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
2011	749	487	390	846
2012	846	621	482	985
2013	985	751	529	1207
2014	1207	871	669	1409
2015	1409	526	567	1368

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын шилмэл сүрэг нь 2011-2014 оны хооронд жилд дунджаар 139-222 тоо толгойгоор өссөн бол 2014-2015 онд малчдын цалинг малаар олгосон, малаа борлуулж үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн зэргээс шалтгаалан 41 тоо толгойгоор хорогдсон байна.

“Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын хийсэн судалгаа, ажиглалтаар нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө хонины амьдын жин Монгол хонины амьдын жингээс дунджаар 1,2-1,5 дахин илүү, ноосны гарц 2,5-3 дахин илүү байдаг байна.

Үүнийг графикаар харьцуулан үзвэл:



Гэвч Орхон, Ерөө үүлдэр, үүлдрийн хэсгийн хонины генефондыг хамгаалж, цус сэлбэх ажил 2005 оноос хойш хийгдээгүй байгаа нь сүргийн бүтэц алдагдах, улмаар ашиг шимийн үзүүлэлт буурах эрсдлийг дагуулж болох талтай юм.

Иймд аймгийн үндсэн брендүүдийн нэг болох Орхон, Ерөө хонины генефондын үндсэн шинж чанар нь хадгалагдаж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагуудаар тогтоолгон хамгаалж, дээрх үүлдрийн эх үүлдрийн хээлтэгчээр ханган, ашиг шим, чанарыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

1.2 Жилийн төсөв, төлөвлөгөө, үр дүнгийн тайланг хуулийн хугацаанд аймгийн ИТХ болон Засаг даргаар хэлэлцүүлэн батлуулаагүй байна.

Үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 “Захирал нь аймгийн Засаг даргатай ажил үйлчилгээний гэрээ байгуулж хоёр тал мөрдөж ажиллана”. 6,3 “... бизнес төлөвлөгөө төсөв, цалингийн сан урамшууллын хэлбэрийг гэрээнд тусгуулан баталгаажуулна” гэж заасан боловч тус газрын захирал 2015 оны үр дүнгийн тайлан, 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулаагүй байгаа нь тус газрын дүрмийн дээрх заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78¹.2.2², 19.1³ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Хэдийгээр тус үйлдвэрийн газрын дарга нь ажлын төлөвлөгөө, тайланг аймгийн Засаг даргад хүргүүлсэн, аймгийн Засаг даргын зүгээс дүгнээгүй гэж тайлбарлаж байгаа боловч энэ нь хүргүүлсэн тухай албан бичиг болон холбогдох бусад баримтаар нотлогдохгүй байна.

Иймээс тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, үр дүнг аймаг, орон нутгийн холбогдох байгууллагууд авч хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдээгүй байна гэж үзэж байна.

Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй ОНӨААТҮГ нь цаашид хэтийн зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулж, хуулийн хугацаанд төсөв, төлөвлөгөөгөө батлуулан, ажлаа тайлагнаж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар дүгнүүлж ажиллах нь зүйтэй юм.

1.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2015 оны 12-р сард тус ОНӨААТҮГ-ын 2013, 2014, 2015 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн баримтуудыг хамруулан хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар “ 41615,0 мянган төгрөгийн орон нутгийн өмчийн эх үүсвэрийг **хувийн** хөрөнгө гэж нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан” зөрчил илэрснийг залруулах албан шаардлага өгсөн боловч санхүүгийн тайланд залруулга хийгээгүй байна.

¹ Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх

² Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн эрх баригчийг томилох

³ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна.

Дээрхээс бусдаар Мэргэжлийн хяналтын газар зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудын зүгээс тус үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаа, сүргийн бүтэц, генефонд зэрэгт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн Аудитын газраас 2015 онд хийгдсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитаар тус газар нь www.shilendans.gov.mn цахим хуудсанд цэс нээлгээгүй, мэдээллээ байршуулаагүй байсан бөгөөд уг зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдсөн боловч өнөөг хүртэл шаардлагатай мэдээллийг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 5.1.1, 5.8 дах заалт, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг зөрчсөн байна.

Иймээс аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан тус үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаа, сүргийн бүтэц, генефонд, малын тоо толгойн болон ашиг шимийн үзүүлэлтүүд, 100 эхээс авч буй төл, малчидтай байгуулж буй гэрээний хэрэгжилт, үр дүн зэрэгт хяналт шалгалт хийн үр дүнг үнэлж, цаашид хэрхэн ажиллах, менежментийн өөрчлөлт хийх эсэхээ тодорхойлох нь зүйтэй юм.

2. ОНӨААТҮГ-ын дүрэмд заасан бүх чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлж, өөрийн орлогыг нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай байна..

2.1 ОНӨААТҮГ нь үйл ажиллагааны чиглэлээ дүрмийн дагуу өргөжүүлэх шаардлагатай байна.

Үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитоор тооцож төлөвлөөгүй бөгөөд 2015 онд зах зээлд мал борлуулсны орлого 7977,0 мянган төгрөг, ноос борлуулснаас 8709,9 мянган төгрөг, үржлийн зориулалтаар мал худалдсны орлого 980,0 мянган төгрөг зэрэг нийт 17666,9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-2

Д/д	Малын төрөл	Зах зээлд борлуулсан			Үржлийн зориулалтаар худалдсан		
		Тоо толгой	Нэг бүрийн дундаж үнэ	Нийт үнэ	Тоо толгой	Нэг бүрийн дундаж үнэ	Нийт үнэ
1	Хуц				4	245,0	980,0
2	Эм хонь	2	115,0	230,0			
3	Эр хонь	57	130,0	7410,0			
4	Эр төлөг	4	84,2	337,0			
5	Нийт дүн	63		7977,0	4		980,0

Тус газрын дүрмийн 4.1-д “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах хуулийн этгээд мөн”, 4.6-д “Хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг өөрийн эзэмшиж буй байшин барилга, машин механизм, тоног төхөөрөмж, мал

амьтдыг ашиглан эрхэлж болно” гэж тодорхойлсон боловч тайлант онд төвлөрүүлсэн үйл ажиллагааны орлого нь цалингийн зардлыг ч санхүүжүүлэх боломжгүй, өөрөөр хэлбэл өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.

Тухайлбал: Аймгийн Засаг даргын 2011 оны 07-р сарын 28-ны өдрийн бүтэц орон тоог баталсан Б/06 тушаалаар зөвхөн цалингийн санд жилд 19800,0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Батлагдсан орон тоо, цалингийн санг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3

д/д	Албан тушаал	Ажиллах хүний тоо	Үндсэн цалин / мян төг /	1 сарын үндсэн нийт цалин / мян төг /	Жилийн цалин/ мян төг /
1	Захирал	1	350,0	350,0	4200,0
2	Мэргэжилтэн	1	300,0	300,0	3600,0
3	Малчин	5	200,0	1000,0	12000,0
	Дүн	7			19800,0

Өмнөх онуудад нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө хонийг маллаж буй малчидтай 100 эхээс 80 төл бойжуулах гэрээ байгуулж байсан бол малчдын цалин хөлс хэтэрхий бага гэж үзэн малчдын мал маллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2015 онд малчидтай байгуулсан гэрээнд “100 эхээс 70 төл бойжуулж, хариуцсан нэг наст болон нийт малыг 94 хувиар онд оруулах” гэж өөрчлөлт оруулж 100 эхээс авах төлийг 2014 оноос 10-аар бууруулж төлөвлөсөн байна.

Тус ОНӨААТҮГ-ын дүрэмд 8 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр тусгагдсан боловч үйл ажиллагааны орлого олох боломжтой шилдэг малыг экспортлох, иргэдийн малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, малын үүлдэрлэг байдал, ашиг шимийг сайжруулах чиглэлийн ажил хийгдээгүй байна.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.2.4-д “Орон нутгийн өмчит Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааны зардал, ажилтны цалинг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу орон нутгийн төсвөөс 2011-2012 онд 20000,0 мянган төгрөгийн, 2013-2014 онд 15000,0 мянган төгрөгийн санхүүжилт олгож байсан бол 2015 онд төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Иймээс дээрх хуулийн дагуу “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал, ажилтны цалинг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, энэ хэмжээгээр 100 эхээс бойжуулах төл, 1 малаас авах ашиг шим, малын тоо толгойг өсгөх, дүрэмд заасан бүх чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөх замаар өөрийн орлогоо нэмэгдүүлж, ашигтай ажиллах нөхцөл боломж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллага, ТЕЗ-ийн дотоод аудитаар судлуулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

2.2 Үндсэн үйл ажиллагаагаа бүрэн санхүүжүүлж чадаагүйгээс алдагдалтай ажилласан байна.

“Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь 2015 онд үндсэн үйл ажиллагаанаас 17666,9 мянган төгрөгийн, төлийн болон нас дэвшилтийн орлого

5479,5 мянган төгрөг буюу нийт 23146,4 мянган төгрөгийн орлого олж, 36518,0 мянган төгрөгийн зардал гарган 13371,6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасан байна.

д/д	Үзүүлэлт	2014.12.31	2015.12.31
1	Борлуулалтын орлого	19245,5	17666,9
2	Борлуулалтын өртөг	31286,6	19607,7
3	Нийт ашиг/алдагдал/	-12041,1	-1940,8
4	Бусад орлого	9075,0	5479,5
5	Ерөнхий ба удирдлагын зардал	5598,7	16910,3
6	Бусад ашиг/алдагдал/	0	0
7	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/	-8564,8	-13371,6
8	Орлогын татварын зардал	0	0
9	Татварын дараах ашиг/алдагдал/	-8564,8	-13371,6
10	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/	-8564,8	-13371,6

Тус үйлвэрийн газар нь өөрийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулж мөрддөггүйгээс тайлант онд захирал, мэргэжилтний шуудан холбооны зардалд 207,7 мянган төгрөг төлсөн атал мобикомын гар утасны төлбөрт дахин 750,9 мянган төгрөг, интернетийн төлбөрт 180,0 мянган төгрөг төлж, онц шаардлагагүй, үр ашиг муутай зардал гаргасан байна.

Цаашид хязгаарлагдмал нөөцийн хүрээнд үр ашиггүй зардлыг санхүүжүүлэхээс татгалзан ажиллах нь зүйтэй юм.

2.3 Цалин, НДШ-ийн 8945,1 их хэмжээний өглөг үүссэн байна.

Тус ОНӨААТҮГ нь 2014 оны эцэст 400,0 мянган төгрөгийн дансны өглөгтэй байсан бол 2015 онд орон нутгийн төсвөөс санхүүжилт олгоогүй, үйл ажиллагааны зардлыг бүрэн санхүүжүүлж чадаагүйгээс 12161,0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд 3 иргэнээс 6000,0 мянган төгрөгийн богино хугацаат, хүүгүй зээл авч 3650,0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, 2350,0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагджээ.



Нийт өглөгийн 73,6 хувийг буюу 8945,1 мянган төгрөгийг цалин, НДШ-ийн өглөг эзэлж байна.

3. Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгасан байна.

“ Сэлэнгэ Үржлийн цөм сүргийн аж ахуй ” ОНӨААТҮГ нь тайлант онд Орхон суурийн малчныг унаажуулж 600,0 мянган төгрөгөөр морь худалдан авсан байна.

Худалдан авсан үндсэн хөрөнгө болон бараа материалыг орлогоор бүртгэж, эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд нь гүйцэтгэж ирсэн байна.

ОНӨААТҮГ-ын даргын 2015 оны 12-р сарын 11-ний өдрийн 07 тоот тушаалаар томилогдсон комисс нь үйлдвэрийн газрын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэсэн бөгөөд тооллогоор 31816,6 мянган төгрөгийн бараа материал буюу мал, 15742,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон байна.

Сэлэнгэ аймгийн Аудитын газраас 2012 онд хийгдсэн эрсдлийн аудитаар өгөгдсөн аж ахуйн дотоодод хэрэглэсэн малыг даргын тушаалаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд зах зээлд 8957,0 мянган төгрөгийн мал нийлүүлж, аж ахуйн дотоодод 1029,0 мянган төгрөгийн, зүй бусын хорогдлоор 882,0 мянган төгрөгийн зардал гаргаж, 1470,0 мянган төгрөгийн мал нядалж, 2832,0 мянган төгрөгийн малыг нас дэвшилтээр зарлагдсан байна.

Дөрөв. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитын явцад дараах зөрчилд албан шаардлага бичигдлээ.Үүнд:

1. Хууль эрхийн актын үндэслэлгүйгээр удирдлагын гар утасны төлбөрийг төлсөн 750,9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх.
2. “ 41615,0 мянган төгрөгийн орон нутгийн өмчийн эх үүсвэрийг **хувийн** хөрөнгө гэж нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан зөрчлийг арилгаж, санхүүгийн тайланд залруулга хийх.

Тав. ДҮГНЭЛТ

Сэлэнгэ нутгийн бренд нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө үүлдрийн хонийг өсгөн үржүүлэх, чанарыг нь хадгалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, үр дүнд холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс үнэлэлт, дүгнэлт хийгдээгүй байна.

- “Сэлэнгэ Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь байгууллагынхаа хэтийн зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулаагүй байна.

- ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, үр дүнд үүсгэн байгуулагч аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргын зүгээс хяналт, шалгалт хийж үр дүнг үнэлээгүй байна.
- Дүрэмд заагдсан үйл ажиллагааны бүх чиглэлээр бүрэн дүүрэн үйл ажиллагаа явуулж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг ашиглаагүй байна.
- Орхон, Ерөө хонины генефондын үндсэн шинж чанар нь хадгалагдаж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагуудаар тогтоолгон хамгаалж, дээрх үүлдрийн эх үүлдрийн хээлтэгчээр ханган, ашиг шим, чанарыг сайжруулах хэрэгтэй байна.
- “Сэлэнгэ-Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны зардал, ажилтны цалинг хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлээгүй байна.
- Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүйгээс алдагдалтай тайлагнагдсан байна.

Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

- “Сэлэнгэ-Үржлийн цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын захиралтай гэрээ байгуулан, үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг үнэлэх, үйл ажиллагааг дэмжин ажиллах.
- 2005 онд баталсан тус ОНӨААТҮГ-ын дүрмийг шинэчлэн батлах.
- Холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан тус үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаа, сүргийн бүтэц, генефонд, малын тоо толгойн болон ашиг шимийн үзүүлэлтүүд, 100 эхээс авч буй төл, малчидтай байгуулж буй гэрээний хэрэгжилт, үр дүн зэрэгт хяналт шалгалт хийн үр дүнг үнэлж, цаашид хэрхэн ажиллах, менежментийн өөрчлөлт хийх эсэхээ тодорхойлох.
- Малыг удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.2.4-дахь “Орон нутгийн өмчит Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааны зардал, ажилтны цалинг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтын дагуу холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, энэ хэмжээгээр 100 эхээс бойжуулах төл, нэг малаас авах ашиг шим, малын тоо толгойн өсөлтийг хангуулах замаар тус үйлдвэрийн газрыг алдагдалгүй ажиллуулах.

“ Сэлэнгэ-Үржлийн Цөм сүргийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын захиралд:

- Үйлдвэрийн газрын хэтийн зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулан, хуулийн хугацаанд төсөв, төлөвлөгөөгөө батлуулан, аймгийн ИТХ болон Засаг даргад ажлаа тайлагнан, дүгнүүлж ажиллах.
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг цахим санд оруулах.
- Дүрмэмд заасан бүх чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг хайн хэрэгжүүлэх.
- Нарийн, нарийвтар ноост Орхон, Ерөө хонины генефондыг хамгаалж дээрх үүлдрийн эх үүлдрийн хээлтэгчийг импортлох асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.
- Малчидтай байгуулсан гэрээг шинэчлэн, 100 эхээс авах төлийн тоо толгой, малын тоо толгойг нэмэгдүүлэх, нэг малаас авах мах, ноос зэрэг өндөр ашиг шимийг хүртэх замаар өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ж.ЦОГТ